

Санхүүгийн зуучлалын хүрээнд – ХААН Банкны Нэмүү өртөгийн сүлжээг сайжруулах санхүүжилтийн Зээл

Улс:	Монгол
Төслийн дугаар:	49388
Бизнесийн салбар:	Санхүү (Банк)
Мэдэгдлийн төрөл:	Хувийн
Байгаль орчны ангилал:	
Зөвлөлийн хурлын тов:	2017 оны 7 дугаар сарын 18
Статус:	Судалгааны түвшинд
Төсөлтэй холбоотой мэдээллийг ил болгосон:	

Төслийн танилцуулга

Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) нь Санхүүгийн зуучлалын хүрээнд (FIF) Монголын хувийн хэвшлийн бичил, жижиг, дунд аж ахуйн нэгжүүд (БЖДААН)-д Нэмүү өртөгийн сүлжээг сайжруулах санхүүжилт (“VCF”) олгох зорилгоор Хаан банкинд 15 сая ам.доллар хүртэлх зээл олгох асуудлыг судалж байна.

Төслийн зорилго

Том ААН-ийн нэмүү өртөгийн сүлжээний нэр хэсэг болох дотоодын БЖДААН-д Монголын тэргүүлэх банкуудын нэгээр дамжуулан урт хугацааны санхүүжилтийг олгож, санхүүгийн хүртээмжийг сайжруулахаас гадна шууд бус замаар эдийн засгийн нэгдмэл байдал болон уян хатан чанарыг бэхжүүлэхэд цогц нөлөө үзүүлэх болно.

Шилжилтийн сорилтууд

Төсөл нь Хаан банкыг Монголын хувийн хэвшлийн БЖДААН-д олгож буй санхүүжилтийн нийлүүлэлтэд байгаа орон зайг нөхөх зорилгоор олгох зээлийг ЕСБХБ-ны багц санхүүжилтээр дэмжинэ. Мөн Хаан банкны бүс нутгийн хүртээмжийг хадгалж тухайн нутгийн шинэ БЖДААН-ийг харилцагч болгосноор орон нутгийн эдийн засгийн өрсөлдөх чадварыг дэмжих болно.

Харилцагчийн мэдээлэл

ХААН БАНК ХХК

Хаан банк нь нийт хөрөнгө, зээл олголтын хэмжээнийхээ хувьд Монгол Улсын хамгийн том арилжааны банк бөгөөд тус банкны нийт хөрөнгө, олгож буй зээл нь нийт зах зээлийн 26.1 болон 27.4 хувийг тус тус эзэлж байна. Тус банк нь нийт 530 гаруй салбар тооцооны төвөөрөө дамжуулан Монгол Улс даяар бүх төрлийн үйл ажиллагаа явуулж байна.

ЕСБХБ-ны санхүүжилт

15 сая америк доллар

Төслийн өртөг

15 сая америк доллар

Байгаль орчин болон нийгмийн үйл ажиллагааны хураангуй

Санхүүгийн байгууллага (ESP 2014) хэмээх ангилалд багтдаг Хаан банк нь ЕСБХБ-ны харилцагч бөгөөд Үйл ажиллагааны шаардлагын 2, 4 болон 9 дүгээр зүйл ангийн шаардлагыг үндсэнд нь хангасан “Байгаль орчны бодлого болон Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны журам”-ыг үйл ажиллагаандаа мөрддөг. Хаан банк нь өөрийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны журмыг ЕСБХБ-ны санхүүжилтээр дамжуулан зээлдүүлэх бүх зээлд мөрдөх бөгөөд, дамжуулан зээлдэгчдийг байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөрийн стандартын үндэсний шаардлагыг хангуулсан байх ёстой. Хаан банк нь Үйл ажиллагааны шаардлагын 2, 4, 9 дүгээр зүйлийн нөхцөлийг тогтмол хангаж, шаардлага хангасан байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны тайланг жил тутам гаргаж танилцуулах үүрэгтэй.

Техникийн хамтын ажиллагаа

Төслийг Хаан банкны БЖДАН-д зээл олгох чадавхийг бэхжүүлэх зорилгоор зээл олголтын хүрээг тэлэх, эрсдэлийн удирдлага болон ажилчдыг чадавхижуулах бусад шаардлагатай сургалтыг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх замаар техникийн хамтын ажиллагааны дэмжлэг үзүүлэх замаар ЕСБХБ-ны зүгээс дэмжиж ажиллахаар төлөвлөж байна.

ААН-ний холбоо барих хаяг

Б. Эрдэнэдэлгэр, Хөрөнгө зохицуулалт хариуцсан захирал

И-мэйл: erdenedelger.b@khanbank.com

Утас: +976 11 332 333

Факс: +976 70 117 023

Вэбсайт: www.khanbank.com

Хаан Банк ХХК, Сөүл гудамж-25, Ш/х #192, Улаанбаатар, Монгол Улс

Бизнес боломжууд

Бизнес боломж болон худалдан авалтын талаар үйлчлүүлэгч ААН-тэй холбогдоно уу.

Ерөнхий мэдээлэл

ЕСБХБ-ны худалдан авалттай холбоогүй төслүүдийн талаарх мэдээллийг доорх хаягаар лавлана уу:

Утас: +44 20 7338 7168; Факс: +44 20 7338 7380

И-мэйл: projectenquiries@ebrd.com

Нийтийн мэдээллийн бодлого (PIP)

ЕСБХБ өөрийн стратеги, бодлого, үйл ажиллагаагаа бусдад илүү сайн хүртээх, ойлгуулах зорилгоор мэдээллийг хэрхэн ил тод болгодог, сонирхогч талуудтайгаа хэрхэн зөвлөлддөг талаар Нийтийн мэдээллийн бодлого (PIP) гаргасан. Энэ тухай мэдээллийг <http://www.ebrd.com/pages/about/what/policies/pip.shtml> хаягаар авч болно.

Төсөлтэй холбоотой гомдол хүлээн авах механизм (PCM)

ЕСБХБ нь өөрийн санхүүжүүлсэн төслүүдээс үүдэн хэн нэгэнд ямарваа хор хохирол учруулсан буюу учруулж болзошгүй талаар нэг буюу түүнээс олон тооны хувь хүн, албан байгууллагын зүгээс мэдүүлсэн гомдлыг хараат бус байдлаар хянан үзэх боломжтой Төсөлтэй холбоотой гомдол хүлээн авах механизм (PCM) бий болгосон.

Механизмын ажиллах журам, англи хэл дээр <http://www.ebrd.com/documents/occo/project-complaint-mechanism-pcm-rules-of-procedure.pdf> холбоосоор, Орос хэл дээр http://www.ebrd.com/downloads/integrity/pcm_rulesr.pdf холбоосоор / Монгол хэл дээр <http://www.ebrd.com/downloads/integrity/pcmrulesmng.pdf> орж үзнэ үү.

ЕСБХБ-ны санхүүжилт олгосон хугацаанаас хойш зөвхөн 12 сарын дотор холбогдох гомдол өргөдлийг Гомдол хүлээн авах механизмын журмын дагуу гаргасан байх ёстой. Хэрэв та гомдол гаргах хугацааны талаар эргэлзэж байгаа бол Механизм хариуцсан ажилтантай pcm@ebrd.com хаягаар эсвэл ЕСБХБ-ны Суурин төлөөлөгчийн газартай холбоо барина уу.